



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Авто замын засвар арчлалтын компаниудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 270,149,274.35 (хоёр зуун далан сая нэг зуун дөчин есөн мянга хоёр зуун далан дөрвөн төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 267,901,496.58 (хоёр зуун жаран долоон сая есөн зуун нэг мянга дөрвөн зуун ерэн зургаан төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 15 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, хавсралтад заасан компаниудын захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн
527 дугаар тогтоолын хавсралт

АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН КОМПАНИУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Авто замын засвар арчлалтын компанийн нэр	Автомашин нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ, (төгрөг)	Хуризмтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
"Төв авто замын засвар арчлалт" төрийн өмчит хувьцаат компани	Мицубиши Пажеро 57-36 ТӨВ	V4545055539	1999/2008	1,606,021.00	1,606,021.00	-	1,500,000.00
	УАЗ-31512 29-84 ХЭА	20128972	2002/2002	5,650,000.00	5,650,000.00	-	2,000,000.00
	Зил-4505 13-91 ХЭА	2876031	1989/1989	750,000.00	750,000.00	-	1,500,000.00
"Харгуй" төрийн өмчит хувьцаат компани	Ниссан Пикап 4782 ХЭА	JN1CJUP22Z008343	2007/2007	26,438,500.00	26,438,500.00	-	1,000,000.00
	Ниссан Пикап 4778 ХЭА	JN1CJUP22Z008352	2007/2007	26,438,500.00	26,438,500.00	-	1,500,000.00
	Ландкрузер 105 41-31 ХЭУ	JTECJ09J005509896	2004/2005	42,000,000.00	42,000,000.00	-	3,000,000.00
	Тоёото Камри 81-35 ХЭА	ACV300083899	2002/2009	16,000,000.00	16,000,000.00	-	2,000,000.00
	Ниссан Навара 63-02 ХЭУ	MNTCCUD40Z00049	2009/2009	42,155,481.45	42,155,481.45	-	3,000,000.00
"Талын зам" төрийн өмчит хувьцаат компани	Усны Зил-130 13-92 ХЭА	2474977	1987/1987	1,174,500.00	1,174,500.00	-	3,000,000.00
	Тоёото Парато 120 06-06 СУЭ	RZJ1200029406	2004/2013	24,174,761.90	24,174,761.90	-	2,000,000.00
	Киа Вонго 17-85 ХОА	KNCSC0662VS2180	1997/2005	9,677,100.00	9,677,100.00	-	1,000,000.00
"Ховд авто замын засвар арчлалт" төрийн өмчит хувьцаат компани	Исүзү 83-16 ХОУ	JALFTR337000019	2003/2004	63,610,910.00	63,610,910.00	-	2,000,000.00
	"Архангай авто замын засвар арчлалт" төрийн өмчит хувьцаат компани	Зил-130 11-83 АРА	2611707	2,713,500.00	2,713,500.00	-	2,000,000.00
"Дорноговь авто замын засвар арчлалт" төрийн өмчит хувьцаат компани	Хьюндай Маяги 43-63 ДГО	KMFGA17FPTC1147	1996/2007	4,960,000.00	3,995,555.56	964,444.44	1,000,000.00
	Хьюндай Старекс 02-98 ДГС	KMJWWNH7HP5U663	2005/2005	2,800,000.00	1,516,666.67	1,283,333.33	1,300,000.00
Нийт дүн				270,149,274.35	267,901,496.58	2,247,777.77	27,800,000.00